



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 25 өдөр

Дугаар А/277

Мөрөн сум

Захирамжид өөрчлөлт оруулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1, 20.2.2, Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйл, 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны 10 дугаар сарын 19-ны өдрийн №87/А2270438/НАГ-2019/07/-НА/ дугаартай “Зөрчил арилгуулах тухай” албан шаардлагын дагуу аймгийн Засаг даргын 2020 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн А/366 дугаар захирамжийн хавсралтын 3 дахь заалтаар “Гоё хотхон” ХХК-д (РД:4139771) “5-8 давхар нийтийн орон сууцны зориулалтай”-гаар эзэмшүүлсэн Мөрөн сумын 1 дүгээр баг Гандангийн баруун талд байршилтай 6712008000 нэгж талбарын дугаартай 5642м² газрын зориулалтыг Мөрөн сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан өөрчилж, “Мод үржүүлгийн зориулалт”-тай болгон үлдсэн 27 жилийн хугацаатайгаар үргэлжлүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн А/366 дугаар захирамжийн хавсралтын 3 дахь заалтын 5 дахь баганыг хүчингүй болгосугай.

3. Газар эзэмшигч “Гоё хотхон” ХХК-д (РД: 4139771)-тай газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул) нарт тус тус зөвшөөрсүгэй.

4. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай)-д үүрэг болгосугай.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ, ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ

М.ХУЯГБААТАР

Захирамж-2023

6712010356